



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

(ХУУЛЬ, ТОГТООЛ, ЗАРЛИГ)

БНМАУ-ын Бага Хурлын Тамгын Газар

№ 6 | 1991 оны арав, арваннэг, арванхоёрдугаар сар (6)

ГАРЧИГ

I. БНМАУ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БАТЛАМЖ, БНМАУ-ЫН ХУУЛЬ

1. Хууль батламжаах тухай № 25	421
2. Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай БНМАУ-ын хууль	421
3. Хууль батламжаах тухай № 26	423
4. «БНМАУ-ын тэмдгийн хураамжийн хуульд нэмэлт оруулах тухай» БНМАУ-ын хууль	423

II. БНМАУ-ЫН БАГА ХУРЛЫН ТОГТООЛ

5. Дипломат харилцаа тогтоох тухай № 61	425
6. Бүгд Найрамдах Литва Улстай дипломат харилцаа тогтоох тухай № 63	426
7. Бүгд Найрамдах Латви Улстай дипломат харилцаа тогтоох тухай № 64	427
8. Бүгд Найрамдах Эстони Улстай дипломат харилцаа тогтоох тухай № 65	428
9. Төр, нийгмийн судлалын Академийн ректорыг томжлох тухай № 66	429
10. Дүрэм батлах тухай № 67	430
11. Эрдэнийн очир одонг сэргээн хэрэглэх тухай № 68	433
12. Монгол Улсын Их цаазын төсөл өргөн мэдүүлэх тухай № 69	435
13. Бруней Даруссалам улстай дипломат харилцаа тогтоох тухай № 70	437

- | | |
|---|-----|
| 14. Бүх цэргийн тусгай шүүхийн зарим гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай № 74 | 437 |
| 15. Зарим улсын тусгаар тогтнолыг зөвшөөрч дипломат харилцаа тогтоох тухай № 75 | 439 |

III. БНМАУ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- | | |
|--|-----|
| 16. Гэндэнгийн Нямдоог элчин сайдын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай № 209 | 440 |
| 17. Лувсандоржийн Даваагийн элчин сайдаар томилох тухай № 210 | 440 |
| 18. Ишцогийн Очирбалыг элчин сайдын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай № 211 | 441 |
| 19. Чойсүрэнгийн Баатарыг элчин сайдаар томилох тухай № 212 | 441 |
| 20. М. Төмөржавыг шагнах тухай № 215 | 442 |
| 21. Д. Эрдэнэпүрэвийг шагнах тухай № 216 | 442 |
| 22. Ц. Батбаатарыг «Шударга журам» медалиар шагнах тухай № 217 | 443 |
| 23. Н. Доржпалмыг «Шударга журам» медалиар шагнах тухай № 218 | 444 |
| 24. Ц. Хүүхэнбаатарыг «Шударга журам» медалиар шагнах тухай № 219 | 444 |
| 25. Зарим хүмүүсийг шагнах тухай № 221 | 445 |
| 26. Эдийн засаг дахь төрийн зохицуулалтыг сайжруулан чиглүүлэх тухай № 222 | 446 |
| 27. Зарим хүмүүсийг шагнах тухай № 224 | 448 |
| 28. Н. Жуков, М. Даулет нарыг шагнах тухай № 226 | 449 |
| 29. Эрхэмсэг ноён Ро Дэ У-г шагнах тухай № 227 | 450 |
| 30. Ш. Оюунд БНМАУ-ын гавьяат зүтгэлтэн цол олгох тухай № 228 | 451 |
| 31. Зарим хүмүүсийг шагнах тухай № 229 | 451 |
| 32. Зарим хүмүүст БНМАУ-ын гавьяат зүтгэлтэн цол олгох тухай № 230 | 456 |
| 33. Зарим хүмүүсийг одон, медалиар нэхэн шагнах тухай № 232 | 457 |
| 34. Э. Бадарт БНМАУ-ын Худалдааны гавьяат ажилтан цол олгох тухай № 240 | 458 |
| 35. Зарим хүмүүсийг одон, медалиар шагнах тухай № 241 | 458 |
| 36. Д. Банзрагчид БНМАУ-ын Гавьяат тэвэрчин цол нэхэн олгох тухай № 242 | 462 |
| 37. «Шударга журам» медалиар шагнах тухай № 243 | 463 |
| 38. «Найрамдал» медалиар шагнах тухай № 244 | 463 |
| 39. М. Г. Воронковыг шагнах тухай № 245 | 464 |

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БАТЛАМЖ**

1991 оны 10 дугаар

Дугаар 25

Улаанбаатар

сарын 17-ны өдөр

ХТГ

ХУУЛЬ БАТЛАМЖЛАХ ТУХАЙ

БНМАУ-ын Бага Хурлаас баталсан «Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай» БНМАУ-ын хуулийг зөвшөөрөн батламжилсугай.

Бүгд Найрамдах Монгол Ард
Улсын Ерөнхийлөгч

Ц. ОЧИРБАТ

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ХУУЛЬ**

1991 оны 10 дугаар

Улаанбаатар

сарын 14-ний өдөр

ХТГ

ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

БНМАУ-ын Засгийн газраас өргөн мэдүүлсэн саналыг харгалзан БНМАУ-ын Бага Хурлаас ТОГТООХ нь:

1. БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хуулийн (ТМ—1991.32) 3 дугаар зүйлийн заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

«3. Үйлдвэрийн газар, байгууллагад тогтоосон онцгой дэглэм, түүний хэрэгжилтийн явцыг сар бүр Улсын Бага Хурал, олон

түмэнд мэдээлж байх, тухайн үйлдвэрийн газар, байгууллагад онцгой дэглэм тогтоосон нөхцөл байдал арилаагүй бол хугацааг нь сунгах тухай саналаа уул хугацаа дуусахаас 10 хоногийн өмнө БНМАУ-ын Бага Хуралд оруулж байхыг БНМАУ-ын Засгийн газарт даалгасугай. БНМАУ-ын Бага Хурал зайлшгүй шаардлагатай гэж үзвэл онцгой дэглэмийг нэг удаа 6 сар хүртэл хугацаагаар сунгаж болно.»

2. Мөн зүйлд дор дурдсан агуулгатай 2, 3, 4 дэх хэсгийг нэмсүгэй:

«Энэ зүйлийн нэг дэх хэсэгт заасан шалтгаанаар хугацаа сунгах шаардлага Улсын Бага Хурлын чуулганы чөлөө цагт гарвал БНМАУ-ын Засгийн газар нь саналаа Улсын Бага Хурлын зохих байнгын хороотой зөвшилцсөний үндсэн дээр дараа чуулганд оруулж батлуулахаар онцгой дэглэмийг 6 сар хүртэл хугацаагаар сунгаж болно.

Онцгой дэглэмийн хугацааг энэ хуульд заасан журмаар сунгаагүй буюу түүнийг дуусгавар болгохоос өмнө БНМАУ-ын Засгийн газрын шийдвэрээр цуцалсан бол онцгой дэглэмийн хугацааг дуусгавар болсонд тооцно.

Онцгой дэглэм дуусгавар болсноос хойш 30 хоногоос доошгүй хугацаа өнгөрсний дараа тухайн үйлдвэрийн газар, байгууллагад дахин онцгой дэглэм тогтоох зайлшгүй шаардлага гарвал БНМАУ-ын Засгийн газар энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан журмаар шийдвэрлэнэ.»

БНМАУ-ын Бага Хурлын
дэргэ

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын
сарийн бичгийн дэргэ

Б. ЧИМИД

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БАТЛАМЖ**

1991 оны 10 дугаар

Дугаар 26

Улаанбаатар

сарын 30-ны өдөр

ХОТ

ХУУЛЬ БАТЛАМЖЛАХ ТУХАЙ

БНМАУ-ын Бага Хурлаас баталсан «БНМАУ-ын тэмдгийн хураамжийн хуульд нэмэлт оруулах тухай» хуулийг зөвшөөрөн батламжиласугай.

Бүгд Найрамдах Монгол Ард
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ХУУЛЬ**

1991 оны 10 дугаар

Улаанбаатар

сарын 24-ний өдөр

ХОТ

**БНМАУ-ЫН ТЭМДГИЙН ХУРААМЖИЙН
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

БНМАУ-ын Бага Хурлаас **ТОГТООХ** нь:

БНМАУ-ын тэмдгийн хураамжийн хуульд дор дурдсан нэмэлт оруулсугай:

1. Доодугаар зүйлэд:

«19. Аж ахуйн нэгж үүсгэн байгуулах гэрээ, төсөл, баримт бичиг батлан гэрчлэхэд 200 төгрөг, аж ахуйн нэгж үүсгэн бай-

гуулсан гэрээ, баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлт батлан гэрчлэхэд 100 төгрөг».

2. Есдүгээр зүйлд:

«г) аж ахуйн нэгжийг улсын бүртгэлд бүртгэж гэрчилгээ олгоход:

- кампани бүртгэхэд 3000 төгрөг;
- хоршоог бүртгэхэд 1500 төгрөг;
- хувинараа эрхлэх аж ахуйг бүртгэхэд 500 төгрөг;
- өөрчлөлтийг бүртгэхэд 100 төгрөг».

БНМАУ-ын Бага Хурлын
дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын
нарийн бичгийн дарга

Б. ЧИМИД

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БАТЛАМЖ

1991 оны 11 дүгээр

Улаанбаатар

сарын 2-ны өдөр

Дугаар 27

ХОТ

ШИЙДВЭР БАТЛАМЖЛАХ ТУХАЙ

Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Израиль улсын хооронд дипломат харилцаа тогтоох тухай БНМАУ-ын Бага Хурлын 1991 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 61 дүгээр тогтоолыг зөвшөөрөн батламжилсугай.

Бүгд Найрамдах Монгол Ард
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
БАГА ХУРАЛЫН ТОГТООЛ**

1991 оны 9 дүгээр

Дугаар 61

Улаанбаатар

сарын 25-ны өдөр

ХТ

ДИПЛОМАТ ХАРИЛЦАА ТОГТООХ ТУХАЙ

БНМАУ-ын Бага Хурлаас ТОГТООХ нь:

Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Израиль улсын хооронд дипломат харилцаа тогтоосугай.

БНМАУ-ын Бага Хурлын
дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын
нэрийн бичгийн дарга

Б. ЧИМИД

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ЕРӨНХИЛЭГЧИЙН БАТЛАМЖ**

1991 оны 11 дүгээр

Дугаар 28

Улаанбаатар

сарын 2-ны өдөр

ХТ

ШИЙДВЭР БАТЛАМЖЛАХ ТУХАЙ

Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Бүгд Найрамдах Литва Улсын хооронд дипломат харилцаа тогтоох тухай БНМАУ-ын Бага Хурлын 1991 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 63 дугаар тогтоолыг зөвшөөрөн батламжилсугай.

Бүгд Найрамдах Монгол Ард
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
БАГА ХУРЛЫН ТОГТООЛ**

1991 оны 10 дугаар

Дугаар 63

Улаанбаатар

сарын 7-ны өдөр

хот

**БҮГД НАЙРАМДАХ ЛИТВА УЛСТАЙ
ДИПЛОМАТ ХАРИЛЦАА ТОГТООХ ТУХАЙ**

БНМАУ-ын Бага Хурлаас ТОГТООХ нь:

Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Бүгд Найрамдах Литва Улсын хооронд дипломат харилцаа тогтоосугай.

**БНМАУ-ын Бага Хурлын
дарга**

Р. ГОНЧИГДОРЖ

**БНМАУ-ын Бага Хурлын
нарийн бичгийн дарга**

Б. ЧИМИД

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ЕРӨНХИГЛӨГЧИЙН БАТЛАМЖ**

1991 оны 11 дүгээр

Дугаар 29

Улаанбаатар

сарын 2-ны өдөр

хот

ШИЙДВЭР БАТЛАМЖЛАХ ТУХАЙ

Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Бүгд Найрамдах Латви Улсын хооронд дипломат харилцаа тогтоох тухай БНМАУ-ын Бага Хурлын 1991 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 64 дүгээр тогтоолыг зөвшөөрөн батламжилсугай.

**Бүгд Найрамдах Монгол Ард
Улсын Ерөнхийлөгч**

П. ОЧИРБАТ

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
БАГА ХУРЛЫН ТОГТООЛ**

1991 оны 10 дугаар

Дугаар 64

Улаанбаатар

сарын 7-ны өдөр

хот

**БҮГД НАЙРАМДАХ ЛАТВИ УЛСТАЙ
ДИПЛОМАТ ХАРИЛЦАА ТОГТООХ ТУХАЙ**

БНМАУ-ын Бага Хурлаас **ТОГТООХ** нь:

Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Бүгд Найрамдах Латви Улсын хооронд дипломат харилцаа тогтоосугай.

**БНМАУ-ын Бага Хурлын
дарга**

Р. ГОНЧИГДОРЖ

**БНМАУ-ын Бага Хурлын
парийн бичгийн дарга**

Б. ЧИМИД

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БАТЛАМЖ**

1991 оны 11 дүгээр
сарын 2-ны өдөр

Дугаар 30

Улаанбаатар
хот

ШИЙДВЭР БАТЛАМЖЛАХ ТУХАЙ

Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Бүгд Найрамдах Эстони Улсын хооронд дипломат харилцаа тогтоох тухай БНМАУ-ын Бага Хурлын 1991 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 65 дугаар тогтоолыг зөвшөөрөн батламжилсугай.

Бүгд Найрамдах Монгол Ард
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
БАГА ХУРЛЫН ТОГТООЛ**

1991 оны 10 дугаар
сарын 7-ны өдөр

Дугаар 65

Улаанбаатар
хот

**БҮГД НАЙРАМДАХ ЭСТОНИ УЛСТАЙ
ДИПЛОМАТ ХАРИЛЦАА ТОГТООХ ТУХАЙ**

БНМАУ-ын Бага Хурлаас ТОГТООХ нь:

Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Бүгд Найрамдах Эстони Улсын хооронд дипломат харилцаа тогтоосугай.

БНМАУ-ын Бага Хурлын
дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын
нэрийн бичгийн дарга

Б. ЧИМНД

**БҮГД НАВРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
БАГА ХУРЛЫН ТОГТООЛ**

1991 оны 10 дугаар

Дугаар 66

Улаанбаатар

сарын 9-ний өдөр

ХТГ

**ТӨР, НИЙГМИЙН СУДААЛЫН АКАДЕМИЙН
РЕКТОРЫГ ТОМИЛОХ ТУХАЙ**

БНМАУ-ын Бага Хурлаас ТОГТООХ нь:

1. БНМАУ-ын Бага Хурлын дэргэдэх Төр, нийгмийн судлаалын Академийн ректорсоор Ядамын Долгоржавыг томилсугай.
2. Төр, нийгмийн судлаалын Академийн ректорын сарын цалингийн хэмжээг 3000 төгрөгөөр тогтоосугай.

БНМАУ-ын Бага Хурлын
дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын
нэрийн бичгийн дарга

Б. ЧИМИД

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
БАГА ХУРАЛЫН ТОГТООЛ**

1991 оны 10 дугаар

Дугаар 67

Улаанбаатар

сарын 12-ны өдөр

хот

ДҮРЭМ БАТЛАХ ТУХАЙ

БНМАУ-ын Бага Хурлаас ТОГТООХ нь:

«Төр, нийгмийн судлалын Академийн дүрэм»-ийг хавсралт ёсоор баталсугай.

**БНМАУ-ын Бага Хурлын
дэргэ**

Р. ГОНЧИГДОРЖ

**БНМАУ-ын Бага Хурлын
нэрийн бичгийн дарга**

Б. ЧИМИД

БНМАУ-ын Бага Хурлын 1991 оны
10 дугаар сарын 12-ны өдрийн 67
дугаар тогтоолоор батлав

**БНМАУ-ЫН БАГА ХУРАЛЫН ДЭРГЭДЭХ ТӨР,
НИЙГМИЙН СУДАЛАЛЫН АКАДЕМИЙН ДҮРЭМ**

НЭГ. Ерөнхий зүйл

1. Төр, нийгмийн судлалын Академи нь (цаашид «Академи» гэж нэрлэнэ) төр судлал, нийгэм, эдийн засаг, улс төрийн асуудлаар суурь болон хавсарга судалгаа явуулж, Улсын Их, Бага Хурал, түүний байгууллагуудыг шинжлэх ухааны мэдээллээр хангахад туслах, төрийн байгууллагын ажилтныг мэргэшүүлэх, мэргэшлийг нь дээшлүүлэх зорилго бүхий эрдэм шинжилгээ, сургалтын байгууллага мөн.

2. Улсын Бага Хурал Академийн дүрэм, төсвийг баталж, ректорыг томино.

3. Академи үйл ажиллагаандаа БНМАУ-ын хууль тогтсомж, төрийн дээд байгууллагын бусад шхйдвэр, энэ дүрмийг удирдлага болгоно.

4. Академи нь Улсын Бага Хурал, Улсын Ерөнхийлөгчийн аппарат, төрийн захиргааны төв, орон нутгийн болон эрдэм шинжилгээ, сургалтын байгууллагатай шууд харилцана.

5. Академи тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

ХОЁР. Академийн үүрэг, эрх

6. Академи дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ:

а) БНМАУ-ын төрийн хөгжил, улс орны хөгжлийн хэтийн болон ойрын зорилттой холбогдсон асуудлаар судалгаа явуулж төрийн эрх барих дээд байгууллага, Ерөнхийлөгч, тэдгээрийн аппаратыг холбогдох мэдээллээр хангах, монголын төрт ёсны түүх, уламжлал, олон түмний санаа бодлыг судалж, төрийн бодлогын талаар санал боловсруулах;

б) төрийнч байгуулалт, эрх зүй, улс төр судлал, социологи, төрийн эдийн засаг, нийгмийн бодлогын асуудлаар судалгаа явуулж, оновчтой хувилбар, чиг баримтлал, санал, зөвлөмж боловсруулах;

в) төрийн хууль тогтоомжийн төслийн онолын үндэслэлийг боловсруулахад оролцож батлагдсан хуулийг таниулах, үр нөлөөг нь судлах, шинжлэх ухааны тайлбар бэлтгэх, дэлгэрүүлэх.

г) дэлхийн улс орнуудын парламентат ёсыг судалж, сонирхсон орнуудын эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэдтэй хамтын судалгаа явуулах;

д) Ардын Их Хурал, Улсын Бага Хурал, Улсын Ерөнхийлөгч болон өөрийн үйл ажиллагаанд шаардагдах мэдээллийн санг бий болгож, өөрийн номын сан байгуулан өргөжүүлэх;

е) төр, захиргааны мэргэшсэн ажилтан бэлтгэх, мэргэшлийг нь дээшлүүлэх;

ж) эрдэм шинжилгээний ажилтан-багш нарыг тодорхой чиглэлээр мэргэшүүлэх, мэргэшлийг нь дээшлүүлэх;

7. Академи дор дурдсан эрх эдэлнэ:

а) Ардын Их Хурал, Улсын Бага Хурал, Улсын Ерөнхийлөгчийн даалгавраар шинжилгээ, судалгаа явуулж төр, захиргааны ажилтны мэргэжил дээшлүүлэх сургалтын жил гүйцэтгэх;

б) туурвисан бүтээл (тайлбар, гарын авлага, санал, зөвлөмж, эрдэм шинжилгээний бичиг, төр, нийгмийн судалгааны мэдээлэл)-ээ нийтлүүлэх, бага хурал, хэлэлцүүлэг, ярилцлага зохиох;

в) эрдэм шинжилгээний ажилд шаардагдах мэдээ, тайлан, судалгааны материалыг холбогдох газруудаас хүсэмжлэн авах; засаг захиргааны байгууллагуудтай мэдээлэл солилцох;

г) эрдэм шинжилгээний ажилтан, багш нарын орон тоо, тэдний гүйцэтгэх ажлын хэмжээг батлагдсан төсөвтөө багтаан бие даан тогтоож байх;

д) өөрийн эрхлэн явуулдаг шинжилгээ судалгааны хүрээнд өөртөө аспирант сургах, тогтоосон дагуу эрдмийн зэрэг хамгаалуулах;

е) өөрийн болон гадаад орны эрдэм шинжилгээ, сургалтын байгууллагатай ажил төрлийн холбоо тогтоож хамтын судалгаа хийх, эрдэм шинжилгээний бага хурал, симпозиум зохион байгуулах, ном, материал гаргах, эрдэм шинжилгээний ажилтан, багш, аспирант солилцох зэргээр хамтран ажиллах;

ж) ажилаа амжилт гаргасан эрдэм шинжилгээний ажилтан-багш, үйлчилгээний хүмүүсийг шагнаж урамшуулах, төрийн болон бусад байгууллагын шагналд тодорхойлох;

ГУРАВ. Академийн удирдлага, зохион байгуулалт

8. Төр, нийгмийн судлалын Академийг ректор толгойлж Академийн зорилго, үүргийг хэрэгжүүлэх ажлыг Улсын Бага Хурлын өмнө хариуцна.

9. Ректор БНМАУ-ын хууль тогтоомжид нийцүүлэн тушаал гаргаж, биелэлтийг зохион байгуулна.

10. Академи нь зорилго, үүргээ биелүүлэхтэй холбогдсон асуудлыг хэлэлцэж хамтын шийдвэр гаргах үүрэг бүхий ректорын зөвлөлтэй байна. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг ректорын тушаалаар батална.

11. Академи нь эрдмийн зэрэг, цол олгох зөвлөлтэй байна. Зөвлөлийг дангаар буюу эрдэм шинжилгээ, сургалтын бусад байгууллагатай хамтран байгуулж ажиллуулна.

12. Эрдэм шинжилгээ, сургалтын асуудлыг онол, арга зүйн хувьд хэлэлцэн шийдвэрлэх эрдмийн зөвлөл ажиллана. Ректор эрдмийн зөвлөлийг удирдаж, гишүүд, эрдэмтэн нарийн бичгийн даргыг батална.

13. Удирдах болон эрдэм шинжилгээний ажилтан, багш, төр, лаборатори, бусад нэгжийн гүйцэтгэх үүргийг тэдгээрийн ажил үүргийн хуваарьар зохицуулна.

14. Төр, нийгмийн судалгааны академийн судлах асуудлын хүрээнд судалгааны ажлыг бие даан явуулах дадлага, чадвартай, гадаад хэлний зохих бэлтгэлтэй хүмүүсийг эрдэм шинжилгээний ажилтнаар сонгон шалгаруулж ажилдуулана.

15. Эрдэм шинжилгээ, сургалтын ажлыг эрхлэн гүйцэтгэх үндсэн нэгж нь төв, лаборатори байна. Төслийн сэдвээр судалгаа явуулах хэсэг, хамтлаг байгуулаж, бусад байгууллагын эрдэмтэн, мэргэжилтнүүдийг оролцуулана.

16. Академид гурван жилийн сургалттай аспирантур ажиллана.

17. Төр, захиргааны ажилтан, орон нутгийн хурлын төлөөлөгчид, сонгуультын мэргэшлийг 1 жил хүртэл хугацаатай төрөлжсөн дамжаагаар дээшлүүнэ. Төгсөгчдөд мэргэжил дээшлүүлсэн тухай үнэмлэх олгоно.

ДӨРӨВ. Академийн санхүү, материаллаг бааз

18. Академи улсын төсвөөс хуваарилаж олгосон буюу өөрийн үйл ажиллагаагаар бий болгосон мөнгө, эд хөрөнгийг эзэмшин ашиглаж, захиран зарцуулна.

19. Академи нь тогтоосон журмын дагуу төсөв зохиож, батлуулан мөрдөхийн хамт төсөвт аж ахуйн тооцоотой үйл ажиллагааг өргөтгөх чиглэл баримтална.

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН БАГА ХУРЛЫН ТОГТООЛ

1991 оны 10 дугаар

Дугаар 68

Улаанбаатар

сарын 14-ний өдөр

хот

ЭРДЭНИЙН ОЧИР ОДОНГ СЭРГЭЭН ХЭРЭГЛЭХ ТУХАЙ

БНМАУ-ын Бага Хурлаас ТОГТООХ нь:

НЭГ. Монгол улсын «Эрдэнийн очир» одонг «сүвдэн шигтгээт», «шүрэн шигтгээт», «оюун шигтгээт» гэсэн гурван зэрэг дэвтэйгээр сэргээн хэрэглэхээр тогтоосугай.

ХОЕР. «Эрдэнийн очир» одонгоор олон улсын харилцааны шударга ардчилсан зарчмыг баталгаж, монгол улстай найрамдал, хамтын ажиллагааг бэхжүүлэхэд онцгой хувь нэмэр оруулж гавьяа байгуулсан гадаад улсын төр, засгийн газрын тэргүүн, төр, олон нийтийн бусад зүтгэлтнийг шагнаж байсугай.

ГУРАВ. «Эрдэнийн очир» одонгийн ерөнхий байдал ба зэрэг дэвийн дүрмийг хавсралтын ёсоор баталсугай.

**БНМАУ-ын Бага Хурлын
дарга**

Р. ГОНЧИГДОРЖ

**БНМАУ-ын Бага Хурлын
өргөн бичгийн дарга**

Б. ЧИМИД

БНМАУ-ын Бага Хурлын 1991 оны
10 дугаар сарын 14-ний өдрийн 68
дугаар тогтоолын хавсралт

«ЭРДЭНИЙН ОЧИР» ОДОНГИЙН ЕРӨНХИЙ БАЙДАЛ БА ЗЭРЭГ ДЭВИЙН ДҮРЭМ

«Эрдэнийн очир» одон «сувдан шигтгээт», «шүрэн шигтгээт», «оюун шигтгээт» зэрэг дэвтэй байна.

Сувдан шигтгээт «Эрдэнийн очир» одон нь шар оосортой, солбисон очир, түүний төв дунд ба толгойд нь цөм сувд эрдэнэ шигтгээтэй байна. Энэхүү одонг гадаад орны төр, засгийн газрын тэргүүн нарт өргөмжлөн олгоно.

Шүрэн шигтгээт «Эрдэнийн очир» одон нь улаан оосортой, солбисон очир, түүний төв дунд ба толгойд нь цөм шүр эрдэнэ шигтгээтэй байна. Энэхүү одонг гадаадын орны төр, Парламентын болон засгийн газрын гишүүд, тэдэнтэй адилтгах бусад зүтгэлтэнд өргөмжлөн олгоно.

Оюун шигтгээт «Эрдэнийн очир» одон нь хөх цэнхэр оосортой, солбисон очир, түүний төв дунд оюу эрдэнэ шигтгээтэй байна. Энэхүү одонг гадаад орны төрийн яамны дэд сайд, тэдгээртэй адилтгах албан тушаалтан, монгол улстай найрамдал, хам-

тын ажлалагааг хөгжүүлэх үйл хэрэгт гавьяа байгуулсан төр, олон нийтийн бусад зүтгэлтэнд өргөмжлөн олгоно.

Сувдан шигтгээт «Эрдэнийн очир» одонг шижир алтаар үйлдэнэ. Шүрэн ба оюун шигтгээт «Эрдэнийн очир» одонг алт, шармад мөнгөөр үйлдэнэ. Сувдан шигтгээт «Эрдэнийн очир» одонгийн өндөр 60 мм, шүрэн шигтгээт «Эрдэнийн очир» одонгийн өндөр 50 мм, оюун шигтгээт «Эрдэнийн очир» одонгийн өндөр 40 мм тус тус байна. Одонгийн зузаан 1,5 мм байна. Солбисон очирын голд 18 мм-ийн голчтой, хүрээгээрээ 10 ширхэг анар суулгасан, төв дундаа 7 мм-ийн голч бүхий эрдэний чулуу шигтгэх суурьтай, 33 мм зузаантай товруу байна. Очирын дэлбээний завсрын зайг улаан өнгийн паалангаар пааландсан байна. Очирын солбицлын зай улаан паалан чимэгтэй байна. Очирьг өөсөртой холбох холбоосны оройд 7 мм голчтой толгойн шигтгэв байна. Одонгийн нэр, зэргийг ар талд нь монгол бичгээр бичнэ. Өөсөрын ар талд одонг энгэрт тогтоох зүүлт байна.

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН БАГА ХУРЛЫН ТОГТООЛ

1991 оны 10 дугаар

Улаанбаатар

Дугаар 69

сарын 20-ны өдөр

хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ЦААЗЫН ТӨСӨЛ ӨРГӨН МЭДҮҮЛЭХ ТУХАЙ

БНМАУ-ын Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах комиссоос оруулсан Монгол Улсын Их цааз (Үндсэн хууль)-ын төслийг хэлэлцээд БНМАУ-ын Бага Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын Бага Хурлаас зохих нэмэлт өөрчлөлт оруулсан Монгол Улсын Их цаазын төслийг Ардын Их Хуралд хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсүгэй.

2. Монгол Улсын Их цаазын төслийг ард нийтээр хэлэлцүүлсэн дүн, Их цаазын шинэ төслийн тухай илтгэлийг Ардын Их Хуралд БНМАУ-ын Ерөнхийлөгч, Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах комиссын дарга П. Очирбат илтгэх нь зүйтэй гэж үзсүгэй.

БНМАУ-ын Бага Хурлын
дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын
нэрийн бичгийн дарга

Б. ЧИМИД

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БАТЛАМЖ

1991 оны 11 дүгээр

Дугаар 31

Улаанбаатар

сарын 2-ны өдөр

хот

ШИЙДВЭР БАТЛАМЖЛАХ ТУХАЙ

Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Бруней Даруссалам улсын хооронд дипломат харилцаа тогтоох тухай БНМАУ-ын Бага Хурлын 1991 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 70 дугаар тогтоолыг зөвшөөрөн батламжилсугай.

Бүгд Найрамдах Монгол Ард
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
БАГА ХУРЛЫН ТОГТООЛ

1991 оны 10 дугаар

Дугаар 74

Улаанбаатар

сарын 24-ний өдөр

хот

БРУНЕЙ ДАРУССАЛАМ УЛСТАЙ
ДИПЛОМАТ ХАРИЛЦАА ТОГТООХ ТУХАЙ

БНМАУ-ын Бага Хурлаас ТОГТООХ нь:

БНМАУ, Бруней Даруссалам улсын хооронд дипломат харилцаа тогтоосугай.

БНМАУ-ын Бага Хурлын
дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын
нэрийн бичгийн дарга

Б. ЧИМИД

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
БАГА ХУРЛЫН ТОГТООЛ

1991 оны 12 дугаар

Дугаар 70

Улаанбаатар

сарын 20-ны өдөр

хот

БҮХ ЦЭРГИЙН ТУСГАЙ ШҮҮХИЙН ЗАРИМ
ГИШҮҮНИЙГ ҮҮРЭГТ АЖЛААС НЬ
ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

БНМАУ-ын Бага Хурлаас ТОГТООХ нь:

Насны тэтгэвэрт гарах хүсэлтийг нь харгалзан Бүх цэргийн тусгай шүүхийн гишүүн Ө. Пүрэв, Б. Дашцэрэв нарыг 1991 оны

12 дугаар сарын 25-ны өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас нь чөлөөдсүгэй.

БНМАУ-ын Бага Хурлын
дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын
нэрийн бичгийн дарга

Б. ЧИМИД

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ЕРӨНХИЯЛӨГЧИЙН БАТЛАМЖ

1991 оны 12 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар 32

Улаанбаатар
хот

ТОГТООЛ БАТЛАМЖЛАХ ТУХАЙ

«Зарим улсын тусгаар тогтнолыг зөвшөөрч дипломат харилцаа тогтоох тухай» БНМАУ-ын Бага Хурлын 1991 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 75 дугаар тогтоолыг зөвшөөрөн батламжилсугай.

Бүгд Найрамдах Монгол Ард
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
БАГА ХУРЛЫН ТОГТООЛ**

1991 оны 12 дугаар

Улаанбаатар

сарын 25-ны өдөр

Дугаар 75

ХОТ

**ЗАРИМ УЛСЫН ТУСГААР ТОГТНОЛЫГ
ЗӨВШӨӨРЧ ДИПЛОМАТ ХАРИЛЦАА
ТОГТООХ ТУХАЙ**

БНМАУ-ын Бага Хурлаас ТОГТООХ нь:

1. Тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлаа ардчилсан үндсэн дээр зарласан Бүгд Найрамдах Азербайжан Улс, Бүгд Найрамдах Армен Улс, Бүгд Найрамдах Беларусь Улс, Бүгд Найрамдах Гүрж Улс, Бүгд Найрамдах Казакстан Улс, Бүгд Найрамдах Кыргызстан Улс, Бүгд Найрамдах Молдова Улс, Бүгд Найрамдах Тажикистан Улс, Туркмен Улс, Бүгд Найрамдах Узбекистан Улс, Украин улсуудын тусгаар тогтнолыг тус тус хүлээн зөвшөөрч БНМАУ-аас эдгээр улстай дипломат харилцаа тогтсоугай.

2. Тусгаар тогтнолыг нь хүлээн зөвшөөрч дипломат харилцаа тогтоох болсныг зохих улсуудад мэдэгдэж нөхцөл байдлыг харгалзан өөлж дараатай яриа хэлэлцээ хийж зохицуулахыг БНМАУ-ын Засгийн газарт зөвшөөрсүгэй.

**БНМАУ-ын Бага Хурлын
дэргэ**

Р. ГОНЧИГДОРЖ

**БНМАУ-ын Бага Хурлын
нерийн бичгийн дарга**

Б. ЧИМИД

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

1991 оны 9 дүгээр

Дугаар 209

Улаанбаатар

сарын 9-ний өдөр

ХОТ

**ГЭНДЭНГИЙН НИЯМДООГ ЭЛЧИН САЙДЫН
ҮҮРЭГТ АЖЛААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ**

Бүгд Найрамдах Монгол Ард Улсаас Америкийн Нэгдсэн Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдын үүрэгт ажлаас Гэндэнгийн Нямдоог чөлөөлсүгэй.

Бүгд Найрамдах Монгол Ард
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

1991 оны 9 дүгээр

Дугаар 210

Улаанбаатар

сарын 9-ний өдөр

ХОТ

**ЛУВСАНДОРЖИЙН ДАВААГИВИЙГ ЭЛЧИН
САЙДААР ТОМИЛОХ ТУХАЙ**

Бүгд Найрамдах Монгол Ард Улсаас Америкийн Нэгдсэн Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар Лувсандоржийн Даваагивийг томиласугай.

Бүгд Найрамдах Монгол Ард
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1991 оны 9 дугаар

Дугаар 211

Улаанбаатар

сарын 9-ний өдөр

ХОТ

ИШЦОГЫН ОЧИРБАЛЫГ ЭЛЧИН САЙДЫН
ҮҮРЭГТ АЖЛААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

Бүгд Найрамдах Монгол Ард Улсаас Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдын үүрэгт ажлаас Ишцогын Очирбалыг чөлөөлсүгэй.

Бүгд Найрамдах Монгол Ард
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1991 оны 9 дугаар

Дугаар 212

Улаанбаатар

сарын 9-ний өдөр

ХОТ

ЧОЙСҮРЭНГИЙН БААТАРЫГ ЭЛЧИН
САЙДААР ТОМИЛОХ ТУХАЙ

Бүгд Найрамдах Монгол Ард Улсаас Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар Чойсүрэнгийн Баатарыг томилсүгэй.

Бүгд Найрамдах Монгол Ард
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

1991 оны 9 дүгээр

Дугаар 215

Улаанбаатар

сарын 23-ны өдөр

хот

М. ТӨМӨРЖАВЫГ ШАГНАХ ТУХАЙ

Хөдөө аж ахуйн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, мал эмнэлэг, биологийн шинжлэх ухааныг хөгжүүлэх, түүнийг ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэхэд оруулсан хувь нэмрийг үнэлж Шинжлэх ухааны академийн дэд ерөнхийлөгч, хөдөө аж ахуйн шинжлэх ухааны салбарын дарга Мятавын ТӨМӨРЖАВЫГ ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН одонгоор шагнасугай.

Бүгд Найрамдах Монгол Ард
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

1991 оны 9 дүгээр

Дугаар 216

Улаанбаатар

сарын 23-ны өдөр

хот

Д. ЭРДЭНЭПҮРЭВИЙГ ШАГНАХ ТУХАЙ

Галт зэвсгээр зэвсэглэсэн хүн амины ноцтой гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлахад эрэлхэг зориг, авхаалж самбаа гарган ажиллаж, өргөсөн тангаргаа нэр төртэй биелүүлснийг үнэлж

Улаанбаатар хотын Цагдаагийн газрын Дипломат байгууллагуудын хамгаалах сумангийн харуулагч, цагдаа Дэлгэрцогтын ЭРДЭНЭПҮРЭВИЙГ ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ одонгоор шагнасугай.

Бүгд Найрамдах Монгол Ард
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРИГ**

1991 оны 9 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 217

Улаанбаатар
хот

**Ц. БАТБААТАРЫГ «ШУДАРГА ЖУРАМ»
МЕДАЛИАР ШАГНАХ ТУХАЙ**

Усны аюулаас хүүхдийн амь аварч иргэнийхээ үүргийг нэр төртэй биелүүлснийг үнэлж, Улаанбаатар хотын Ажилчны дүүргийн 13 дугаар хорооны иргэн Цэрэнгийн БАТБААТАРЫГ «ШУДАРГА ЖУРАМ» медалиар шагнасугай.

Бүгд Найрамдах Монгол Ард
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРАЛГ**

1991 оны 9 дүгээр

Дугаар 218

Улаанбаатар

сарын 23-ны өдөр

хот

**Н. ДОРЖПАГМЫГ «ШУДАРГА ЖУРАМ»
МЕДАЛИАР ШАГНАХ ТУХАЙ**

Мал сүргээ байгалийн гэнэтийн аюулаас хорогдолгүй авран хамгаалж иргэнийхээ үүргийг нэр төртэй биелүүлснийг үнэлж Дундговь аймгийн Өлзийт сумын «Хоёрдугаар таван жил» нэгдлийн малчин Наваанжамцмы ДОРЖПАГМЫГ «ШУДАРГА ЖУРАМ» медалиар шагнасугай.

Бүгд Найрамдах Монгол Ард
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРАЛГ**

1991 оны 9 дүгээр

Дугаар 219

Улаанбаатар

сарын 23-ны өдөр

хот

**Ц. ХҮҮХЭНБААТАРЫГ «ШУДАРГА ЖУРАМ»
МЕДАЛИАР ШАГНАХ ТУХАЙ**

Галын аюулаас 2 хүүхдийн амийг аварч иргэнийхээ үүргийг нэр төртэй биелүүлснийг үнэлж Дундговь аймгийн Өлзийт сумын «Хоёрдугаар таван жил» нэгдлийн малчин Цагаан-Өвгө-

ний ХҮҮХЭНБААТАРЫГ «ШУДАРГА ЖУРАМ» медалар шагнасугай.

Бүгд Найрамдах Монгол Ард
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1991 оны 9 дүгээр

Дугаар 221

Улаанбаатар

срэн 23-ны өдөр

хот

ЗАРИМ ХҮМҮҮСИЙГ ШАГНАХ ТУХАЙ

Улсад олон жил идэвх зүтгэлтэй ажиллаж олон шинэ бүтээл оновчтой санал гарган үйлдвэрлэлд нэвтрүүлэн үр дүнд хүргэснийг үнэлж Булган аймгийн Магсаржав сангийн аж ахуйн дарга Гэлэг-Очирын ДИНААЖАВЫГ ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН одонгоор, Баян-Өлгий аймгийн орон сууц нийтийн аж ахуйн конторын ажилчин Хусайны БАЙДЕКИЙГ АЛТАН ГАДАС одонгоор шагнасугай.

Бүгд Найрамдах Монгол Ард
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1991 оны 9 дүгээр

Дугаар 222

Улаанбаатар

сарын 28-ны өдөр

хот

ЭДИЙН ЗАСАГ ДАХЬ ТӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ САЙЖРУУЛАН ЧИГЛҮҮЛЭХ ТУХАЙ

Улс орны эдийн засгийн өөрийгөө хангах, нөхөн үйлдвэрлэх чадвар сул, санхүүгийн нөөц хүрэлцээгүй, технологи, техникийн түвшний хувьд ихээхэн хоцрогдолтойн зэрэгцээ шийдвэрлэх нөлөө бүхий гадаад нөхцөл байдал эрс өөрчлөгдсөний улмаас эдийн засгийн хямрал түргэн гүнзгийрч, зах зээлийн харилцаанд шилжих амаргүй үйл явцтай давхцаж байна. Энэ хүнд үед хүмүүсийг зах зээлийн эдийн засгийн нөхцөлд бие даан ажиллаж амьдрах сэтгэхүйн бэлтгэл, арга ухаанд сургах ажил хангалтгүй, төрийн захиргааны байгууллагын зохион байгуулах чадвар сул байгаагаас нөөц бололцоогоо дээд зэргээр дайчилж чадаагүй, гаргасан шийдвэр нь тэр бүр үр дүнд хүрэхгүй байна. Энэ бүхэн нь эдийн засаг дахь төрийн зохицуулалтыг хүчтэй болгохыг шаардаж байгааг тэмдэглэж, БНМАУ-ын Ерөнхийлөгчийн тууай хуулийн 10 дугаар зүйлийн нэг дэх заалтыг баримтлан ТОГТООХ нь:

Нэг. Төрийн зохицуулалтыг сайжруулах талаар БНМАУ-ын Засгийн газар (Ерөнхий сайд Д. Бямбасүрэн)-т дараах зүйлийг чиглэл болгосугай:

1. Үнийн зохицуулалт, хяналт болон индексчлэлийг Засгийн газрын байнгын анхааралд авч үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, барааны хомсдлыг багасгах арга хэмжээ авах;

2. Үнийн өсөлтийг хязгаарлах болон мөнгөний ханш бууралтыг тогтоон барих, цаашид тогтворжуулах талаар авах арга хэмжээг 1991 оны 11 дүгээр сарын 1-ний наана Монголбанктай хамтран боловсруулж Улсын Бага Хуралд оруулан шийдвэрлүүлэх;

3. Олон улсын байгууллага, гадаад орны тусламжийн хөрөнгийг улс орны экспортын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, импортыг дороздуулахад голлон зориулахын зэрэгцээ түүнийг то-

дорхой хэсгийг эдийн засгийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд зохицуулан зарцуулж байх;

4. Зах зээлийн нөхцөлд БНМАУ-ын эдийн засаг, нийгмийн удирдлагын схемийг, дэд систем, орон нутгийн удирдлагын схемийн хамт 1992 онд багтаан боловсруулах;

5. Улс ардын аж ахуйн дээд түвшний стратегийн төлөвлөлт болон жилийн төлөвлөгөө, үйлдвэрлэлийн илгжийн өөрөө төлөвлөх тогтолцоог зах зээлийн эдийн засгийн зарчимд нийцүүлэн бий болгож дээд, дунд, доод түвшин болон орон нутгийн төлөвлөлтийг холбох, хэрэгжүүлэх арга замыг тогтоож түүнийг мэдээллээр хангах, бүртгэх, тайлагнах зарчмыг үзүүлэлтийн хамт боловсруулан 1992 оноос эхлэн мөрдүүлэх;

6. Эдийн засаг, үйлдвэрлэл, технологи, патентын талаар гадаадтай харилцах төслүүд боловсруулах, хяналт тавих, хэрэгжүүлэх болон экспорт импортын үйл ажиллагаатай холбогдсон мэргэжлийн туслаалцааг үйлдвэр, аж ахуйн газар, өмчтөнд үзүүлэх, зуучлах үүрэг гүйцэтгэх ажлыг үр нөлөөтэй зохион байгуулан эрчимжүүлэх;

7. Төр, засгаас авах арга хэмжээний үндэслэлийг сайжруулахад онцгой анхаарч, эрдэмтэн мэргэжилтэн нарыг Засгийн газар болон түүний байгууллагуудад хавсран ажиллуулах, суурь судалгаа болон улс орны хэрэгцээ шаардлага, төр засгийн шийдвэр, хууль тогтоомжийг шинжлэх ухааны арга зүй, мэргэжлийн хувьд үндэслэхтэй холбогдсон хавсарга судалгааг эрдэмтдийн нэр зааж, тэдэнтэй гэрээ байгуулан санхүүжүүлдэг журамд 1992 оноос эхлэн шинжих, шаардлагатай чухал асуудлаар эрдэмтэн, мэргэжилтэн, үйлдвэрлэлийн удирдагчдын зөвлөлгөөн хийж, санааыг авч тусгаж байх;

8. Зах зээлийн боловсон хүчин бэлтгэх, хөдөлмөрчдийн зах зээлийн харилцааны мэдлэгийг дээшлүүлэх, сэтгэл зүйн бэлтгэлийг хангах ажлыг зохион байгуулах;

9. Хуулийн биелэлтийг зохион байгуулах, хянан шалгах ажлыг эрчимжүүлэхэд төрийн захиргааны бүх шатны байгууллагын ажлыг чиглүүлж, хуулийг мөрдөх явцад гарч буй асуудлуудыг байнга судалж, түүнд шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах санааыг Улсын Бага Хуралд оруулж байх;

10. Эдийн засгийн эсрэг чиглэсэн зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.

Хоёр. БНМАУ-ын Бага Хуралд дараах зүйлийг зөвлөмж болгосугай:

1. Мөнгөний бодлогын үндсэн чиглэлийг 1992 оны 1 дүгээр сарын 1-ний наана хэлэлцэн батлах;

2. «Шударга өрсөлдөөнийг дэмжиж, дангаар ноёрхохыг хязгаарлах тухай» хуулийг энэ онд багтаан хэлэлцэн батлах.

Гурав. Орон нутгийн Ардын Хурлын Тэргүүлэгчид, гүйцэтгэх захиргаадад дараах зүйлийг чиглэл болгосугай:

1. Зах зээлд шилжих үйл явцыг төрийн захиргааны байгууллагын байнгын хяналтад авч, түүнийг зохицуулан зохион байгуулах асуудлыг эн тэргүүний үүргээ гэж үзэж ажиллах;

2. Бүс нутгийн цогцолбор хөгжлийн асуудлыг аймаг, хотууд бие даан буюу хамтран боловсруулж өөрсдийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэж байх.

Бүгд Найрамдах Монгол Ард
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1991 оны 10 дугаар

Дугаар 224

Улаанбаатар

сарын 17-ны өдөр

хот

ЗАРИМ ХҮМҮҮСИЙГ ШАГНАХ ТУХАЙ

Гаалийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгааг үнэлж, дор дурдсан хүмүүсийг БНМАУ-ын одон, медалиар шагнасугай.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

Гомбын ПУНЦАГДАШ

— Замын-үүд дахь гаалийн газрын дарга

АЛТАН ГАДАС ОЛОНГООР:

1. Ахамжавын **ЖАМБЯНДОРЖ** — Улсын гаалийн ерөнхий газрын хяналт шалгалт харнуулсан ерөнхий байцаагч
2. Товуугийн **ОРГОДОЛ** — Алтанбулаг дахь гаалийн байгууллагын байцаагч

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Чойжилсүрэнгийн **ЭНХТАЙВАН** — Замын-үүд дахь гаалийн газрын улсын байцаагч
2. Пэрэнлэйн **ЦЭРЭН-ӨЛЗИЙ** — мөн газрын улсын байцаагч
3. Төмөрбаатарын **БАЯРМАА** — Улаанбаатар хотын гаалийн газрын гаалийн улсын байцаагч

Бүгд Найрамдах Монгол Ард
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРАЛГ

1991 оны 10 дугаар

Дугаар 226

Улаанбаатар

сарын 17-ны өдөр

хот

Н. ЖУКОВ, М. ДАУЛЕТ НАРЫГ ШАГНАХ ТУХАЙ

Улсын хил хамгаалах үүргээ нэр төртэй биелүүлж, хил зөрчин ашиг хонжоо хайгчдыг байгаль, цаг уурын хүнд нөхцөлд удаа дараа нэрүүлэн баривчлахад байгуулсан гавьяаг үнэлж Хилсийн нэгдүгээр хорооны салааны захирагч, ахмад Ногоогийн **ЖУКОВЫГ ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН**

одонгоор, мөн хорооны хидчин, ахлагч Мукариягийн **ДАУЛЕ-ТЫГ ЦЭРГИЙН ХҮНДЭТ** медалиар шагнасугай.

Бүгд Найрамдах Монгол Ард
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРАЛГ**

1991 оны 10 дугаар

Дугаар 227

Улаанбаатар

сарын 17-ны өдөр

хот

ЭРХЭМСЭГ НОЁН РО ДЭ У-Г ШАГНАХ ТУХАЙ

БНМАУ, БНСУ-ын хооронд найрсаг харилцаа тогтоож, хамтын ажиллагааг өргөтгөж хөгжүүлэхэд биечлэн анхаарч их хувь нэмэр оруулсныг нь өндөр үнэлж хоёр орны ард түмний найрамдлыг улам гүнзгийрүүлэх эрмэлзлэлийн билэгдэл болгож; Бүгд Найрамдах Солонгос Улсын Ерөнхийлөгч Эрхэмсэг ноён Ро Дэ У-г сувдан шигтгээт «Эрдэнийн очир» одонгоор шагна-сугай.

Бүгд Найрамдах Монгол Ард
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

1991 оны 10 дугаар

Дугаар 228

Улаанбаатар

сарын 29-ний өдөр

ХОТ

**Ш. ОЮУНД БНМАУ-ЫН ГАВЬЯАТ
ЗҮТГЭЛТЭН ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ**

Боловсролын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж
осверийн үснийг сурган хүмүүжүүлэх үйлсэд хөдөлмөрийн өндөр
эмгэнэт гаргаж байгааг үнэлж Сүхбаатар аймгийн Түмэнцогт
сумын 10 жилийн дунд сургуулийн газар зүйн багш Шаран-
нямбуугийн ОЮУНД БНМАУ-ын ГАВЬЯАТ БАГШ цол ол-
госугай.

Бүгд Найрамдах Монгол Ард
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

1991 оны 10 дугаар

Дугаар 229

Улаанбаатар

сарын 29-ний өдөр

ХОТ

ЗАРИМ ХҮМҮҮСНИГ ШАГНАХ ТУХАЙ

Боловсролын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажил-
лаж байгааг үнэлж их, тусгай мэргэжлийн дунд сургууль, мэр-
гэжлийн сургаат үйлдвэрлэлийн төв болон сэтгэхий боловсро-
лын сургууль, цэцэрлэгийн багш, сурган хүмүүжүүлэгч, ажил-

чин дор дурдсан хүмүүсийг БНМАУ-ын одон, медалиар шагна-
насугай.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Лхамсүрэнгийн
БАЛДАНДОРЖ — Баянхонгор аймгийн сургалт
заах аргын кабинетын арга
зүйч
2. Намжилдаръяагийн
БАЯРТОГТОХ — Төв аймгийн Зууимод хотын
10 жилийн 1 дүгээр дунд
сургуулийн багш
3. Ламбасүрэнгийн
БАНЗРАГЧ — Улаанбаатар хотын 10 жи-
лийн 3 дугаар дунд сургуу-
лийн багш
4. Жамсранцэрэнгийн
НАЦАГ — мөн хотын 4 дүгээр дунд
сургуулийн захирал
5. Самдангийн ШАРАА — мөн хотын 6 дугаар дунд
сургуулийн бага ангийн багш
6. Адъяагийн
ЦЭНДСҮРЭН — Монгол улсын их сургуулийн
багш
7. Хандын
ГЭНДЭНЖАМЦ — мөн сургуулийн багш
8. Жамъяншаравын ДҮГЭР — Хүүхэд асрач хүмүүжүүлэх
төвийн захирал

«АЛТАН ГАДАС» ОДОНГООР:

1. Цамбын БАДАРЧ — Баянхонгор аймгийн Баян-
Өндөр сумын дунд сургуу-
лийн багш
2. Гаваагийн ХҮРЭЛХҮҮ — Сэлэнгэ аймаг дахь Ойн
мэргэжлийн сургалт үйлд-
гэрлэлийн төвийн мастер
багш
3. Сэнгээгийн БАНЗРАГЧ — Дорноговь аймгийн Сайн-
шанд хотын 2 дугаар бага
сургуулийн багш
4. Самбуугийн НАСТ — Өвөрхангай аймгийн Арвай-
хээр хотын 10 жилийн 2
дугаар дунд сургуулийн бага
ангийн багш

- | | |
|------------------------------|--|
| 5. Чойндонгийн ГОМБО-ЖАВ | — Төв аймгийн Аргалант сумын дунд сургуулийн захирал |
| 6. Намсрайн ЖАМБАЛ-СҮРЭН | — мөн сургуулийн багш |
| 7. Маанийн БААСАН | — мөн аймгийн Зуунмод хотын 10 жилийн 1 дүгээр дунд сургуулийн хичээлийн эрхлэгч |
| 8. Индэрлагийн БАТТУУГА | — Улаанбаатар хотын 26 дугаар цэцэрлэгийн нярав |
| 9. Лувсанцэрэнгийн ГАЛМАНДАХ | — мөн хотын 52 дугаар дунд сургуулийн багш |
| 10. Зоригтын ДУЛАМЖАВ | — мөн хотын 16 дугаар дунд сургуулийн бага ангийн багш |
| 11. Төмөрийн ГОМБО-СҮРЭН | — мөн хотын Боловсролын газрын дэргэдэх монгол бичиг сургалтын төвийн эрхлэгч |
| 12. Дайчаагийн ДОРЖ | — Монгол улсын их сургуулийн захирал |
| 13. Сономын ЧИМЭДЦЭРЭН | — мөн сургуулийн багш |
| 14. Лхамжавын ЦЭРЭН-ДОРЖ | — Хөдөө аж ахуйн их сургуулийн тэнхмийн эрхлэгч |
| 15. Өлзийн ВААНЧИГ | — Цэцэрлэгийн багшийн колледжийн багш |

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

- | | |
|------------------------------|---|
| 1. Халасын ХОЖАНИЯЗ | — Баян-Өлгий аймгийн сургалт үйлдвэрлэлийн төвийн багш |
| 2. Хандын БАЛЖИННЯМ | — Баянхонгор аймгийн Баянхонгор хотын 2 дугаар дунд сургуулийн багш |
| 3. Арьяабазарын ДААГАН-СҮРЭН | — мөн аймгийн Жаргалант сумын дунд сургуулийн хичээлийн эрхлэгч |
| 4. Сангидоржийн ШИЙРЭВ | — мөн аймгийн Өлзийт сумын дунд сургуулийн захирал |

5. Совдын ГАНТӨМӨР — Говь-Алтай аймгийн Цогт сумын дунд сургуулийн багш
6. Эхгийн НОРОВ — мөн аймгийн Алтай хотын 2 дугаар дунд сургуулийн багш
7. Дамдинсүрэнгийн РАГЧАА — мөн аймгийн Тонхил сумын бригадын бага сургуулийн багш
8. Совдын ТЭРБИШ — мөн аймгийн Шарга сумын дунд сургуулийн бага ангийн багш
9. Санжийн ЖАДАМБАА — Дорноговь аймаг дахь Анагаах ухааны дунд сургуулийн багш
10. Самдангийн ДОНДОВ-ЦООДОЛ — Өвөрхангай аймаг дахь мэргэжлийн сургаалт үйлдвэрлэлийн төвийн мастер багш
11. Борын ЦЭРЭНДОРЖ — мөн аймгийн Арвайхээр хотын 1 дүгээр бага сургуулийн хичээлийн эрхлэгч
12. Дагаагийн ТОВУУЖАВ — Төв аймгийн Угтаал дахь мэргэжлийн сургаалт үйлдвэрлэлийн төвийн багш
13. Гомбын ЧОГДОН-ХОРЛОО — мөн аймгийн Зуунмод хотын 1 дүгээр дунд сургуулийн хичээлийн эрхлэгч
14. Данзангийн ЛХААХҮҮ — Ховд аймаг дахь Хөдөө аж ахуйн техникумын багш
15. Дагвын НАЯНТАЙ — Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын дунд сургуулийн багш
16. Самсгалын ПҮРЭВЖАВ — мөн аймгийн Галт сумын дунд сургуулийн хичээлийн эрхлэгч
17. Цэсэгийн ЖАЛБАА — Дархан хот дахь усны аж ахуйн техникумын багш
18. Рвнцэнгийн ЛХАГВА-СҮРЭН — мөн хот дахь Политехник сургаалтын төвийн захирал

19. Бат-Очирын НИЯМСҮРЭН — Чойр хотын 10 жилийн дунд сургуулийн багш
20. Нацагдоржийн ТҮМЭН-ӨЛЗИГ — мөн сургуулийн багш
21. Жигмэдцэдэнгийн БАЯРАА — Улаанбаатар хотын 24 дүгээр дунд сургуулийн бага ангийн багш
22. Сономбалын БЯМБАЖАВ — мөн хотын 3 дугаар дунд сургуулийн багш
23. Миномын ДИНЕШХААН — мөн хотын 73 дугаар цэцэрлэгийн эрхлэгч
24. Цэдэвийн ГҮНСЭЭ — мөн хотын 48 дугаар дунд сургуулийн бага ангийн багш
25. Анандын АХАМСҮРЭН — мөн хотын 5 дугаар дунд сургуулийн бага ангийн багш
26. Хяравгаагийн ШАРАВМАА — Налайх дахь сургалт үйлдвэрлэлийн төвийн мастер багш
27. Хүрэлийн СҮХБААТАР — Техникийн их сургуулийн тэнхмийн эрхлэгч
28. Далхаасүрэнгийн ДАШДЭНДЭВ — Хөдөө аж ахуйн их сургуулийн багш
29. Шархүүгийн ЛЯНХУА — Улаанбаатар хот дахь Анагаах ухааны дунд сургуулийн багш

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

1991 оны 10 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 230

Улаанбаатар
хот

**ЗАРИМ ХҮМҮҮҮСТ БНМАУ-ЫН ГАВЬЯАТ
ЗҮТГЭЛТЭН ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ**

Үндэсний урлагийг хөгжүүлэхэд олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж байгааг үнэлж, дор дурдсан хүмүүст БНМАУ-ын гавьяат зүтгэлтэн цол олгосугай.

**БНМАУ-ЫН УРЛАГИЙН ГАВЬЯАТ
ЗҮТГЭЛТЭН ЦОЛООР**

— Бирваагийн **МӨНХДОРЖ** — Армийн драмын театрын
найруулагч

БНМАУ-ЫН ГАВЬЯАТ ЖҮЖИГЧИН ЦОЛООР

— Баатарсүрэнгийн **ЦЭРЭНПАГМА** — Драммын улсын академик
театрын жүжигчин
— Гомбын **МЯГМАРНАРАН** — мөн театрын жүжигчин
— Гомбын **ОЧИРБАТ** — Өвөрхангай аймгийн хөгжимт
драмын театрын жүжигчин

Бүгд Найрамдах Монгол Ард
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

1991 оны 10 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 232

Улаанбаатар
хот

**ЗАРИМ ХҮМҮҮСИЙГ ОДОН, МЕДАЛИАР
НЭХЭН ШАГНАХ ТУХАЙ**

Гэмт хэрэг, хэв журмын зөрчилтэй тэмцэх үүргээ нэр төртэй биелүүлж байсан Төв аймгийн цагдан сэргийлэх хэлтсийн сэргийлэгч агсан Цэвээний ГОМБОСҮРЭНГ ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН одонгоор, Толгойтын цахилгаан станцын харуулын салааны сэргийлэгч агсан Баяжихын ЛУВСАНГ ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ одонгоор, Булган аймгийн цагдан сэргийлэх ангийн жолооч агсан Дамдинсүрэнгийн ДААРИЙ, Дорноговь аймгийн цагдан сэргийлэх хэлтсийн мөрдөн байцаагч агсан Санжмятавын СҮХБААТАР, Улаанбаатар хотын цагдан сэргийлэх газрын эргүүд ротын сэргийлэгч агсан Цэндийн БАДАМХАНД нарыг «ШУДАРГА ЖУРАМ» медалиар, Сүхбаатар аймгийн цагдан сэргийлэх ангийн сэргийлэгч агсан Гомбосүрэнгийн ЖАРГАЛ, Эрдэнэт хотын цагдан сэргийлэх хэлтсийн сэргийлэгч агсан Гомбожавын ДУНГАР нарыг ЦЭРГИЙН ХҮНДЭТ медалиар тус тус нэхэн шагнасугай.

Бүгд Найрамдах Монгол Ард
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРАЛГ**

1991 оны 12 дугаар

Дугаар 240

Улаанбаатар

сарын 17-ны өдөр

хот

**З. БАДАРТ БНМАУ-ЫН ХУДАЛДААНЫ
ГАВЬЯАТ АЖИЛТАН ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ**

Худалдааны байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, хөдөлмөрднийг худалдаагаар үйлчлэх, үйлдвэрийн түүхий эднийг бэлтгэх ажилд хөдөлмөрийн өндөр амжилт гаргаж байгааг үнэлж Өвөрхангай аймгийн Баянгол сумын хэрэглээний хоршооны агент Зүмбийн БАДАРТ БНМАУ-ЫН ХУДАЛДААНЫ ГАВЬЯАТ АЖИЛТАН цол олгосугай.

Бүгд Найрамдах Монгол Ард
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРАЛГ**

1991 оны 12 дугаар

Дугаар 241

Улаанбаатар

сарын 17-ны өдөр

хот

**ЗАРИМ ХҮМҮҮСИЙГ ОДОН, МЕДАЛНАР
ШАГНАХ ТУХАЙ**

Худалдааны байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгааг үнэлж дор дурдсан хүмүүсийг БНМАУ-ын одон, медалиар шагнасугай.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Гомбодоржийн ЦАГААН — Улсын их дэлгүүрийн ахлах худалдагч
2. Гомбожамцын УРТНАСАН — БНМАУ-аас ЗСБНХУ-д суугаа худалдааны төлөөлөгчийн орлогч

АЛТАН ГАДАС ОДОНГООР

1. Нацагийн ЖААМАА — Хүнсний барааны бөөний худалдааны газрын ачигч
2. Содонгоогийн ЧИЛХААЖАВ — Улаанбаатар хотын 49 дүгээр дэлгүүрийн бригадын ахлагч
3. Манжаагийн ГАНХҮҮ — Бөөний худалдааны нэгдлийн ачигч
4. Доованчигийн ДОЛЖИН — Баянхонгор аймгийн ХБ-ын трестийн ахлах тогооч
5. Бадарчийн ХАЛТАР — Мөн аймгийн хэрэглээний хоршоодын холбооны дарга
6. Дүгэрийн БААРАНХҮҮ — Говь-Алтай аймгийн хэрэглээний хоршоодын холбооны дарга
7. Мөөгдөөгийн БАСАН — Увс аймгийн хэрэглээний хоршоодын холбоонд нягтлан бодогч
8. Ядамсүрэнгийн ЗИНАМИДАР — Завхан аймгийн Отгон сумын хэрэглээний хоршооны агент
9. Намжилын АХААСҮРЭН — Ховд аймгийн Мөст сумын хэрэглээний хоршооны холбооны дарга
10. Түмэнжаргалын ЧУЛУУН — Монголын хэрэглээний хоршоодын төв холбооны хэлтсийн дарга
11. Балбарын НЯМАА — Худалдаа, үйлдвэрийн яамны мэргэжилтэн
12. Ишийн СҮХБААТАР — Батлан хамгаалах яамны цэргийн худалдаа ахуйн үйлчилгээний газрын дарга

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР

1. Пунцагийн ЧИМЭД-ЦЭРЭН — Хөвсгөл аймгийн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний ангийн дарга
2. Нямжавын БУД — Сүхбаатар аймгийн худалдааны трестийн худалдагч
3. Ендонгийн ЭНХБААТАР — Дорнод аймаг дахь дамжилга баазын ачигч
4. Шаравын СҮХБААТАР — Худалдааны төхөөрөмжийн засвар, зарлал чимэглэлийн газрын механикч
5. Аюушийн АХАГВАЖАВ — Улаанбаатар хотын худалдаа, нийтийн хоолны ерөнхий компанийн нарийн боовны цехийн ажилчин
6. Номтын ЦЭГМИД — Мөн компанийн нарийн боовны цехийн ажилчин
7. Самбуугийн ӨНӨРХҮҮ — Улсын их дэлгүүрийн ня-бо
8. Бямбын ДОЛГОРСҮРЭН — Баянхонгор аймгийн хүнсний дэлгүүрийн худалдагч
9. Чойжлажавын ОЧИРСҮХ — «Жуулчин» нэгтгэлийн зочид буудлын дарга
10. Должингийн ГАНСҮХ — Хэнтий аймгийн хэрэглэний хоршоодын холбооны ня-бо
11. Норовын ГОМБОДОРЖ — Дундговь аймгийн хэрэглэний хоршоодын холбооны дарга
12. Самдангийн ДАШДЭНДЭВ — Төв аймгийн Баянцогт сумын хэрэглээний хоршооны дарга
13. Банзрагчийн БАТЦЭРЭН — Мөн аймгийн Баянжаргалан сумын хоршооны түүхий эд бэлтгэлийн эрхлэгч
14. Амгалангийн ЧИМЭД-ДОРЖ — Завхан аймгийн хоршоодын холбооны ня-бо
15. Асвэрдийн ЦЭВЭГМИД — Мөн аймгийн Түдэвтэй сумын хоршооны нярав

- | | |
|----------------------------------|---|
| 16. Самдангийн
АГЧИНСҮРЭН | — Ховд аймгийн Чандмань сумын хэрэглээний хоршооны дарга |
| 17. Нацагийн БАЗАРЖАВ | — Дорноговь аймгийн Сайхандулаан сумын хэрэглээний хоршооны ня-бо |
| 18. Чүлтэмийн
ГУУЛИНБААТАР | — Хэнтий аймгийн Дархан сумын хэрэглээний хоршооны агент |
| 19. Лувсангийн ГЭНДЭН-
ДАРЖАА | — Өмнөговь аймгийн Манлай сумын хэрэглээний хоршооны ажилчин |
| 20. Хандын ХАЙМАН | — Мөн аймгийн Ханбогд сумын хоршооны ня-бо |
| 21. Долгорын ЦЭДЭН-
БААЖИР | — Мөн аймгийн Баян-Овоо сумын хоршооны түүхий эд бэлтгэлийн эрхлэгч |
| 22. Цэдэвийн
ДОЛГОРСҮРЭН | — Дорнод аймгийн Сэргэлэн сумын хоршооны нярав |
| 23. Цэрэнлахамын
СУГАРДАШ | — Мөн аймгийн Булган сумын хоршооны дарга |
| 24. Должингийн АХАА-
СҮРЭН | — Хөвсгөл аймгийн Мөрөн хотын хоршооны мужван |
| 25. Бадрахын АХАМСҮРЭН | — Мөн аймгийн хэрэглээний хоршоодын холбооны харууцаагатай нарийн бичгийн дарга |
| 26. Цэндийн ОРШИХ | — Увс аймгийн хэрэглээний хоршоодын холбооны ерөнхий ня-бо |
| 27. Дашийн РЭГЖИЙ | — Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын хоршооны худалдагч |
| 28. Дамбийнямын
РЭНЦЭНХАНД | — Дорноговь аймгийн Хажуу-Улаан хорооны хоршооны худалдагч |
| 29. Шакений УАТХАН | — Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын хоршооны түүхий эд бэлтгэлийн эрхлэгч |

30. Равдандоржийн ПҮРЭВЖАЛ — Монголын хэрэглээний хөршөөдмн төв холбооны хэлтсийн дарга
31. Мижидсүрэнгийн ЗАГДРАГЧАА — Зах зээл судлаалын хүрээлэнгийн секторын эрхлэгч
32. Баатарын ДАШХҮҮ — Батлан замгаалах яамны цэргийн худаадааны газрын ажилчин
33. Сандагийн ТҮДЭВДОРЖ — Өвөрхангай аймгийн хэрэглээний хөршөөдмн холбооны орлогч дарга

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРАЛГ

1971 оны 12 дугаар

Дугаар 242

Улаанбаатар

сарын 17-ны өдөр

хот

Д. БАНЗРАГЧИД БНМАУ-ЫН ГАВЬЯАТ
ТЭЭВЭРЧИН ЦОЛ НЭХЭН ОЛГОХ ТУХАЙ

Төмөр замын албанд олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаад илчт тэрэгний ослоос олон хүний амийг аварч гавьяа байгуулан нас барсан Улаанбаатар төмөр замын илчт тэрэгний депогийн машинч Дагдангийн БАНЗРАГЧИД БНМАУ-ЫН ГАВЬЯАТ ТЭЭВЭРЧИН цол нэхэн олгосугай.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРАЛГ**

1991 оны 12 дугаар

Дугаар 243

Улаанбаатар

сарны 17-ны өдөр

хот

«ШУДАРГА ЖУРАМ» МЕДАЛИАР ШАГНАХ ТУХАЙ

Өвлийн хүйтэнд төөрч, амь насаа алдах аюулд орсон хүний амийг аварч иргэнийхээ үүргийг нэр төртэй биелүүснийг үнэлж Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын харьяат Баасансүрэнгийн БАТХҮҮГ «ШУДАРГА ЖУРАМ» медалиар шагнаасугай.

**Бүгд Найрамдах Монгол Ард
Улсын Ерөнхийлөгч**

П. ОЧИРБАТ

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРАЛГ**

1991 оны 12 дугаар

Дугаар 244

Улаанбаатар

сарны 17-ны өдөр

хот

«НАЙРАМДАЛ» МЕДАЛИАР ШАГНАХ ТУХАЙ

МЗНН-ийн анхан шатны зөвлөлийн даргаар олон жил ажиллаж, хоёр орны ард түмний найрамдал, хамтын ажиллагааны ололт амжилтыг сурталчлахад идэвх зүтгэлтэй ажилласныг үнэлж Баянхонгор аймгийн Баянхонгор хотын харьяат, өндөр

настан Намхайн ДУЛАМХАНДЫГ «НАЙРАМДАЛ» медалар шагнасугай.

Бүгд Найрамдах Монгол Ард
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ЕРӨНХИРЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1991 оны 12 дугаар

Дугаар 245

Улаанбаатар

сарын 17-ны өдөр

хот

М. Г. ВОРОНКОВЫГ ШАГНАХ ТУХАЙ

Манай орны химийн шинжлэх ухааныг хөгжүүлэх үйл хэрэгт оруулсан хувь нэмрийг нь үнэлж ЗХУ-ын Шинжлэх ухааны академийн Сибирийн салбарын Эрхүүгийн Органик химийн хүрээлэнгийн захирал, академич ВОРОНКОВ Михаил Григорьевичийг АЛТАН ГАДАС одонгоор шагнасугай.

Бүгд Найрамдах Монгол Ард
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

Эмхтгэсэн Ч. Жаргалсайхан
Техник редактор Б. Оюундвалгэр
Хянагч С. Итгэл

Зах № 37

Үйлдвэрт шилжүүлсэн 1992 оны 1-р сарын 6-нд.
Өрөлтөд 1992 оны 1-р сарын 6-нд. Хэвлэлтэд
1992 оны 1-р сарын 16-нд. Цаасны хэмжээ
60х84/16. Хэвлэлийн хуудас 3.0. Хэвлэсэн тоо
6000 ширхэг.

Засгийн газрын хэвлэх үйлдвэр